

**Олон улсын хүрээлэн буй орчны эрх зүй дэх
үндсэн зарчим ба Монгол Улсын эрх зүйн хэм
хэмжээнд тусгах нэр томъёоны асуудал**

**Basic Principles of International Environmental Law
and Legal Terminology Issues in Mongolian Law**

Сүхбаатарын Сүхчулуун

Хууль зүйн ухааны доктор (LL.D.)

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн

Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш,

Улаанбаатар хот, Монгол Улс.

sukhchuluun.s@num.edu.mn



[Товч утга]

Хүрээлэн буй орчны эрх зүйн зарчим гэж тогтсон тодорхой жагсаалт байхгүй хэдий боловч “principle of state have sovereignty over their natural resources and the responsibility not to cause transboundary environmental damage”; “principle of preventive action”; “precautionary principle”; “polluter pays principle”; “principle of common but differentiated responsibility” “principle of co-operation”; “principle of sustainable development” зэрэг зарчим байдаг тухайд олон улсын хүрээлэн буй орчны эрх зүйн бүтээлд тэмдэглэжээ. Энэхүү өгүүлэлд олон улсын хүрээлэн буй орчны эрх зүйн зарчмыг Монгол улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгахад үүсэж болох нэр томьёоны асуудлыг судалсан болно. Тухайлбал, “Principle of preventive action” болон “Precautionary principle” хоорондын ялгааг хэрхэн тодорхойлох, үндэсний эрх зүйн хэм хэмжээнд цаашид хэрэглэж болох нэр томьёоны орчуулга дээр санал дэвшүүлсэн болно.

[Түлхүүр үг]

Байгалийн баялаг дахь эзэн орны байнгын бүрэн эрхтэй байх зарчим, Бохирдуулагч нь төлөх зарчим, Нийтлэг боловч ялгаатайгаар хариуцлага хүлээх зарчим, Хүрээлэн буй орчинд үзүүлэх шалтгаан нөхцөл болон үүсэх эрсдэл бүхий хохирол хоорондын шалтгаант холбоог тогтооход шинжлэх ухааны бүрэн үндэслэл нотолгоог шаардах зарчим, Хүрээлэн буй орчинд үзүүлэх шалтгаан нөхцөл болон үүсэх эрсдэл бүхий хохирол хоорондын шалтгаант холбоог тогтооход шинжлэх ухааны бүрэн үндэслэл нотолгоог шаардахгүй байх зарчим.

I. Оршил

Олон улсын хүрээлэн буй орчны эрх зүй дэх үндсэн зарчим гэдэгт хамаарах хүрээг тодорхой системчилсэн ойлголт байхгүй боловч тус салбарын эрдэмтэн бүтээлдээ, тухайлбал Philippe Sands дараах зарчим байж болохыг тэмдэглэжээ. Тодруулбал, олон улсын хүрээлэн буй орчны эрх зүйд “principle of state have sovereignty over their natural resources and the responsibility not to cause transboundary environmental damage”; “principle of preventive action”; “principle of co-operation”; “principle of sustainable development”; “precautionary principle”; “polluter pays principle”; “principle of common but differentiated responsibility” зэрэг зарчим багтана гэж үзжээ¹. Энэхүү өгүүлэлд эдгээр олон улсын хүрээлэн буй орчны эрх зүй дэх зарчмыг үндэсний эрх зүйн хэм хэмжээнд тусгахад үүсэж болох нэр томьёоны асуудлыг авч үзэх болно. Ингэхдээ, “Principle of co-operation” зарчмыг “Хамтын ажиллагааны зарчим”, “Principle of sustainable development” зарчмыг “Тогтвортой хөгжлийн зарчим” гэсэн нэр томьёогоор илэрхийлэхэд хэлзүйн хувьд тухайлсан асуудал байхгүй гэж үзсэн тул эдгээрээс бусад зарчмын талаар судалсан болно.

II. Олон улсын хүрээлэн буй орчны эрх зүй дэх зарчмууд

Энэ хэсэгт дээр дурдсан олон улсын хүрээлэн буй орчны эрх зүйн үндсэн зарчимд хамаарах зарчим тус бүрийн агуулга болон тэдгээрийг үндэсний эрх зүйн хэм хэмжээнд хэрэглэхтэй холбоотой нэр томьёоны орчуулгад үүсэж болохыг асуудлыг авч үзэх юм.

A. “Principle of state have sovereignty over their natural resources and the responsibility not to cause transboundary environmental damage” зарчим, түүний нэр томьёоны орчуулга

Энэхүү зарчмыг олон улсын нийтийн эрх зүйн ном бүтээлд “улс байгалийн нөөцөө эзэмших халдашгүй эрхийн зарчим”, “улс өөрийн хязгаараас гадна орчинд хохирол үл учруулах зарчим” гэж орчуулан хэрэглэжээ². Мөн судлаач Н.Баярмаа “Байгалийн баялаг дахь эзэн орны байнгын бүрэн эрхтэй байх болон бусад улсын хүрээлэн буй орчинд хор хохирол учруулахгүй байх зарчим” гэсэн нэр томьёог хэрэглэжээ³. Түүнчлэн, Т.Сэнгэдорж нар бүтээлдээ “Улс бүхэн өөрийн

¹ Sands, Philippe. *Principles of International Environmental Law*. Second edition. Cambridge: Cambridge University Press, 2003, at 231.

² Хууль зүй, дотоод хэргийн яам, “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл, Олон улсын нийтийн эрх зүй, гарын авлага, УБ., 2007, тал 137.

³ Н.Баярмаа, “Байгалийн баялаг дахь эзэн орны байнгын бүрэн эрхийн зарчим болон уул уурхайн салбарын техник эдийн засгийн үндэслэлийн хууль зүйн үр дагавар” Хууль зүйн судалгаа бүтээлийн цахим сан, <https://legaldata.mn/buteel/pdf?id=315> Сүүлд хандсан, 2025.04.17.

нутаг дэвсгэр дэх байгалийн нөөц баялгийг бүрэн эзэмшин ашиглах эрхтэй байх зарчим⁴” гэсэн нэр томьёог хэрэглэжээ. Эдгээрээс дүгнэвэл, Монгол Улсын хувьд “Principle of state have sovereignty over their natural resources and the responsibility not to cause transboundary environmental damage” зарчмыг эрх зүйн хэм хэмжээнд хэл зүйн нэр томьёоны хувьд тогтсон орчуулга байхгүй боловч судлаач нарын бүтээлд тус тусын нэр томьёог орчуулан хэрэглэж байна. Харин эдгээр бүтээлд тус зарчмын талаарх агуулгын талаар тодорхойлон тусгаагүй байдаг.

Тус зарчим нь 1972 оны “Хүний хүрээлэн буй орчин” хурлын “Стокгольмын тунхаглал” (The Stockholm declaration on the human environment, UN, 1972)-ын 21 дэх зарчим болон 1992 оны “Хүрээлэн буй орчин ба хөгжлийн тухай Рио-де-Жанейрогийн тунхаглал⁵” (The Rio declaration on environment and development, UN, 1992)-ын 2 дугаар зарчимд тус тус тусгалаа олсон гэж тайлбарлагддаг. Тодруулбал, уг зарчим нь тухайн улс нь өөрийн орны байгалийн баялагт бүрэн эрхийг эдлэхийн зэрэгцээ бусад улсын эсхүл тухайн улсын өөрийн харьяалан шийдвэрлэх хүрээнд багтахгүй хүрээлэн буй орчинд хохирол учруулахгүй байх хариуцлага, үүргийг хүлээнэ гэж тайлбарлагддаг⁶.

Б. “Principle of preventive action” зарчим, түүний нэр томьёоны орчуулга

Энэхүү зарчмыг олон улсын нийтийн эрх зүйн ном бүтээлд “болгоомжлох арга хэмжээ авах зарчим⁷” гэж орчуулан хэрэглэсэн гэж үзэж болох ч олон улсын хүрээлэн буй орчны эрх зүйн өөр нэг зарчим болох “precautionary principle” гэх нэр томьёоноос хэл зүйн хувьд хэрхэн ялгах гэдэг асуудал үүсэж болох юм. Иймд, “Principle of preventive action” болон “Precautionary principle” зарчим хоорондын ялгааг тодорхой болгох шаардлага үүсэхээр байна. Тус зарчим нь 1972 оны “Хүний хүрээлэн буй орчин” хурлын “Стокгольмын тунхаглал”-ын 21 дэх зарчимд заасан хүрээлэн буй орчинд хохирол учруулахаас урьдчилан болгоомжлох, эсхүл тэрхүү хохирол учрах эрсдэл, шалтгаан зэргийг багасгах эсхүл хязгаарлах арга хэмжээг авч

⁴ Т.Сэнгэдорж, С.Энхмэнд, С.Энхсаруул, Олон улсын экологийн эрх зүй, Уб.,2015, тал 13.

⁵ Монгол Улсын Их Хурлын тогтоол, “НҮБ-ын Бага хурлаас дэвшүүлсэн зорилтыг дэмжих тухай” 1993.06.15-ны өдрийн дугаар 43 тогтоолд “Хүрээлэн буй орчин ба хөгжлийн тухай Рио-де-Жанейрогийн тунхаглал” гэж орчуулжээ. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6367> Сүүлд хандсан, 2025.03.12.

⁶ Sands, Philippe. *Principles of International Environmental Law*. Second edition. Cambridge: Cambridge University Press, 2003, at 236.

⁷ Хууль зүй, дотоод хэргийн яам, “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл, Олон улсын нийтийн эрх зүй, гарын авлага, Уб.,2007, тал 137.

хэрэгжүүлэх гэсэн үүрэгтэй салшгүй холбоотой гэж тайлбарлагдана⁸. Тус зарчмын хүрээнд авч хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагаа нь тухайн хохирол бодитоор тохиолдохоос өмнө буюу эрт үе шатанд авч хэрэгжүүлбэл зохих ёстой байдаг⁹. Япон улсын хүрээлэн буй орчны эрх зүйн судлаач Китамура Ёшинобү “Principle of preventive action” болон “Precautionary principle” зарчим нь дараах шинжээр ялгагдана гэж үзжээ¹⁰ /Хүснэгт 1-ийг үзнэ үү/.

Хүснэгт 1. “Principle of preventive action” болон “Precautionary principle” зарчим хоорондын харьцуулалт

Precautionary principle	Principle of preventive action	Зарчим
Амь нас, эрүүл мэнд, амьдралын орчин, экосистем, эх болсон байгаль орчин	Амь нас, эрүүл мэнд, амьдралын орчин, эх болсон байгаль орчин	Хамгаалагдах ашиг сонирхол
Хохирол үүсэхээс нэн өмнө	Хохирол үүсэхээс өмнө	Зарчим хэрэглэгдэж эхлэх хугацаа
Одоо үеийнхэн, Ирээдүй үеийнхэн	Одоо үеийнхэн	Хамгаалах үе
Амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол, нөхөх аргагүй хохирол бүхий хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл, нөхөн сэргээхэд үлэмж хэмжээний зардал шаардагдах хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл	Амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол, амьдрах орчинд учирсан хохирол	Хөндөгдөж болох зүйлс
Бүрэн шаардахгүй.	Шаардана	Үүсэж болох эрсдэлийг шинжлэх ухааны бүрэн үндэслэлээр нотлох эсэх

Эх сурвалж: 北村善宣『環境法、第5版』(有斐閣、2020年)57頁。

⁸ Sands, Philippe. *Principles of International Environmental Law*. Second edition. Cambridge: Cambridge University Press, 2003, at 236.

⁹ Ibid, at 237.

¹⁰ 北村善宣『環境法、第5版』(有斐閣、2020年)77頁。

В. “Precautionary principle” зарчим, түүний нэр томьёоны орчуулга

Энэхүү зарчмыг нэр томьёоны тайлбар тольд “Урьдчилан сэргийлэх зарчим” гэж орчуулан тайлбарлажээ. Тодруулбал, “Precautionary principle-Урьдчилан сэргийлэх зарчим” нь “... хүрээлэн буй орчинд ноцтой эсхүл нөхөх аргагүй хохирол учруулах аюул байгаа тохиолдолд шинжлэх ухааны бүрэн дүүрэн үндэслэл байхгүй байна гэсний үндсэн дээр, байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх үр ашигтай арга хэмжээ авахыг хойшлуулах шалтгаан болохгүй байх ёстой.¹¹ ...” гэж тайлбарлажээ. 1992 оны “Хүрээлэн буй орчин ба хөгжлийн тухай Рио-де-Жанейрогийн тунхаглал”-ын 15 дугаар зарчимд “Хүрээлэн буй орчныг хамгаалахын тулд урьдчилан сэргийлэх зарчим нь бүх улсын хувьд өөрийн орны чадамжид нийцүүлэн өргөн хүрээнд хэрэгжих ёстой. Нэн ноцтой эсхүл нөхөн сэргээх боломжгүй хохирол учрах эрсдэл бүхий байгаа тохиолдолд шинжлэх ухааны бүрэн дүүрэн үндэслэл байхгүй байгаа нь хүрээлэн буй орчинд учруулж буй доройтлыг урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр ашигтай арга хэмжээ авахыг хойшлуулах үндэслэл болохгүй байх ёстой.” гэж заасан. Энэ утгаараа тус зарчим нь 1/ хүрээлэн буй орчинд доройтол үүсэх болсон түүний үндэслэл ба тэрхүү хохирол хооронд шалтгаант холбооны хамаарлыг шинжлэх ухааны бүрэн дүүрэн нотолгоог шаардахгүй, 2/ үүсэж болох эрсдэл бүхий хохирол нь ноцтой эсхүл нөхөн сэргээх боломжгүй байх, 3/ шинжлэх ухааны бүрэн дүүрэн үндэслэл байхгүй байгааг үндэслэн зөвхөн үр ашигтай арга хэмжээ (**cost-effective measures**) авахыг хойшлуулах үндэслэл болохгүйг заасан бөгөөд хүрээлэн байгаа орчныг хамгаалах эдийн засгийн, зохицуулалтын, мэдээллийн арга хэрэгслийг хэрэглэх боломж нээлттэй байна¹². Тус зарчмын хүрээнд, хэдийгээр шинжлэх ухааны бүрэн дүүрэн үндэслэл өгч чадахгүй байгаа тухайн эрсдэлийн хувьд ирээдүйд үүсэж болох эрсдэлийг одоо үед хэмээн тооцож хүрээлэн буй орчны доройтол үүсэхээс урьдчилан сэргийлэхийг бодлого тодорхойлогч буюу олон улсын эрх зүйн хувьд тухайн улс авч хэрэгжүүлэх ёстой гэсэн агуулгыг илэрхийлнэ¹³. Түүнчлэн, судлаач Philippe Sands “principle of preventive action” зарчим нь 1930-аад оны сүүл үеэс олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгагдаж байсан бол “precautionary principle” зарчим нь 1980-д оны дунд үеэс олон улсын эрх зүйн хэм хэмжээнд хэрэглэгдэж ирсэн гэж үзжээ¹⁴.

¹¹ Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль, Худалдааны бодлогын нэр томьёоны тайлбар толь бичиг, УБ.,2020, тал 278.

¹² 大塚直『環境法、第4版』（有斐閣、2020年）55頁。

¹³ 高村ゆかり「予防原則・予防的アプローチ」西井正弘・鶴田順編『国際環境法講義』（有信堂、2021年）28頁。

¹⁴ Sands, Philippe. *Principles of International Environmental Law*. Second edition.

Дээрхээс үзвэл, “Principle of preventive action” зарчмыг **“Болгоомжлох арга хэмжээ авах зарчим”**, “Precautionary principle” зарчмыг **“Урьдчилан сэргийлэх зарчим”** гэсэн хэлзүйн нэр томьёог хэрэглэн үндэсний эрх зүйн хэм хэмжээнд хэрэглэх нь төдийлөн оновчтой биш юм. Учир нь хэлзүйн хувьд “Болгоомжлох арга хэмжээ авах зарчим” болон “Урьдчилан сэргийлэх зарчим” гэх нэр томьёо нь олон улсын хүрээлэн буй орчны эрх зүйд хэрэглэгдэж буй дээрх 2 зарчмын ялгааг тодорхой илэрхийлж чадахгүй юм. Иймд, “Principle of preventive action” зарчмыг “хүрээлэн буй орчинд үзүүлэх шалтгаан нөхцөл болон үүсэх эрсдэл бүхий хохирол хоорондын шалтгаант холбоог тогтооход шинжлэх ухааны бүрэн үндэслэл нотолгоог шаардах зарчим”, “Precautionary principle” зарчмыг “хүрээлэн буй орчинд үзүүлэх шалтгаан нөхцөл болон үүсэх эрсдэл бүхий хохирол хоорондын шалтгаант холбоог тогтооход шинжлэх ухааны бүрэн үндэслэл нотолгоог шаардахгүй байх зарчим” гэж тус хоёр зарчмын гол ялгагдах шинжээр нэр томьёог орчуулан хэрэглэх нь зүйтэй.

Г. “Polluter pays principle” зарчим, түүний нэр томьёоны орчуулга

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 82 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Агаарыг хамгаалах хөтөлбөр”-ийн гурав дахь хэсгийн “в/эхний ээлжинд Улаанбаатар хот, хүн ам төвлөрөн суурьшсан бусад томоохон суурин газрын агаарын бохирдлыг бууруулахад түлхүү анхаарч, бохирдлыг эдийн засгийн хөшүүрэг хэрэглэх замаар багасгаж, «Бохирдуулагч нь төлөх зарчим»-ыг тууштай баримтлахаас гадна хил дамжин ирж буй бохирдолд тавих хяналтыг сайжруулах, өргөжүүлэх.¹⁵” гэж заажээ. Мөн, Монгол улсын Засгийн газрын 2018.06.20-ны өдрийн “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” дугаар 189 тогтоолд “... Хог хаягдлын эдийн засгийн зохицуулалтыг сайжруулах, үүсгэгч нь хариуцаж, бохирдуулагч нь төлөх эко төлбөрийн эрх зүйн орчныг бүрдүүлэх...¹⁶” гэж тусгажээ. Үүнээс үзвэл, үндэсний эрх зүйн хэм хэмжээнд “Polluter pays principle” зарчмыг “Бохирдуулагч нь төлөх зарчим” гэсэн нэр томьёог хэрэглэж эхэлсэн байна. Энэхүү зарчмыг эдийн засгийн ухаанаас үүсэлтэй гэж тодорхойлж болох бөгөөд хүрээлэн буй орчинд доройтол учруулсантай холбогдуулан авах арга хэмжээний зардлыг тухайн шалтгаан нөхцөл болсон үйл ажиллагааг хийсэн

Cambridge: Cambridge University Press, 2003, at 267.

¹⁵ Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 82 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Агаарыг хамгаалах хөтөлбөр” Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=201639> Сүүлд хандсан, 2025.03.12.

¹⁶ Монгол улсын Засгийн газрын 2018.06.20-ны өдрийн “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” дугаар 189 тогтоол, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13515> Сүүлд хандсан, 2025.03.12.

этгээд урьдчилан хариуцаж төлөх ёстой гэсэн санаанд суурилжээ¹⁷. Тодруулбал, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-ын Зөвлөлөөс 1972 онд гаргасан “Хүрээлэн буй орчны бодлогын талаарх олон улсын эдийн засагт хамаарах хөтөч зарчим буюу Recommendation on Guiding Principles Concerning the International Economic Aspects of Environmental Policies”-д тусгалаа олсон¹⁸. Тус зарчим нь олон улсын худалдаан дахь шударга бус байдлыг засахын тулд гарсан түүхтэй. Бохирдуулагч аж ахуйн нэгжид тухайн улс нь өөрийн төсвөөс бохирдлыг арилгахад чиглэсэн дэмжлэг үзүүлдэг байх нь тус аж ахуйн нэгжийн хувьд бохирдлыг арилгах дарамтыг үүрэхгүйгээр бараа, үйлчилгээг боловсруулах боломжтой. Үр дүнд нь үүнтэй адил бодлого хэрэгжүүлдэг улсын бараа, үйлчилгээнээс илүү хямд үнээр зах зээлд нийлүүлэх боломж бүрдэх тул энэхүү шударга бус өрсөлдөөнийг засах зорилготой уг зарчим үүссэн. Энэ утгаараа хүрээлэн буй орчныг хамгаалахаас илүүтэй олон улсын худалдааны өрсөлдөөнийг хамгаалахад чиглэж үүссэн зарчим юм¹⁹.

Д. “Principle of common but differentiated responsibility” зарчим, түүний нэр томъёоны орчуулга

Энэхүү зарчмыг “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын суурь конвенц”-ийн 3.1 дэх хэсгийг “Конвенцийн зорилтод хүрэх, түүний заалтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа Талуудын мөрдлөг болгох зарим зүйл гэвэл: 1.Талууд хүн төрөлхтний өнөөгийн ба ирээдүйн үеийнхний сайн сайхны тусын тулд өөр өөрсдийн болоод бүх нийтийн үүрэг хариуцлагадаа нийцүүлэн эрх тэгш байдлын үндсэн дээр уур амьсгалын тогтолцоог хамгаална. ...²⁰” гэж орчуулжээ. Гэвч тус конвенцийн англи хэл дээрх хувилбарт “*The Parties should protect the climate system for the benefit of present and future generations of humankind, on the basis of equity and in accordance with their common but differentiated responsibilities and respective capabilities. ...*” гэж заажээ. Монгол хэл дээрх орчуулгад “..., on the basis of equity and in accordance with their common but differentiated responsibilities and respective capabilities...” гэх утга санааг илүү тодорхой болгохын тулд “Талууд хүн төрөлхтний өнөөгийн ба ирээдүйн үеийнхний сайн сайхны тусын тулд эрх тэгш байдлын үндсэн дээр, мөн өөр өөрсдийн нийтлэг боловч ялгаатай хариуцлага, болон тухайн улсын чадавхын дагуу уур амьсгалын тогтолцоог хамгаална.

¹⁷ 北村善宣『環境法、第5版』（有斐閣、2020年）55頁。

¹⁸ Sands, Philippe. *Principles of International Environmental Law*. Second edition. Cambridge: Cambridge University Press, 2003, at 281.

¹⁹ 北村善宣『環境法、第5版』（有斐閣、2020年）58頁。

²⁰ “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын суурь конвенц” монгол хэл дээрх орчуулга, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail/10695> Сүүлд хандсан, 2025.04.14.

...” гэж орчуулах нь “нийтлэг боловч ялгаатайгаар хариуцлага хүлээх зарчим”-ын агуулгыг илэрхийлэхэд ач холбогдолтой байж болох юм.

Дээрх зарчим нь одоо болон ирээдүй үеийн төлөө даян дэлхийн хүрээлэн буй орчныг хамгаалах явдал нь өндөр хөгжилтэй улс эсхүл хөгжиж буй орон эсэхээс үл хамаарч бүхий л улс хариуцлага хүлээх боловч өндөр хөгжилтэй улсын хувьд даян дэлхийн хүрээлэн буй орчны асуудалд түүхэн хөгжлийн явцад илүүтэй нөлөөлсөн, хөгжиж буй орнуудтай харьцуулахад эдийн засаг, техник технологийн хөгжил давуу байх тул тэдгээр улс хооронд харилцан зөрүү байгааг хүлээн зөвшөөрч, өндөр хөгжилтэй улс хөгжиж буй улстай харьцуулахад илүү хариуцлага хүлээнэ гэсэн утгыг илэрхийлдэг байна²¹.

III. Дүгнэлт

Энэхүү өгүүлэлд олон улсын хүрээлэн буй орчны эрх зүйн үндсэн зарчимд тооцогддог “principle of state have sovereignty over their natural resources and the responsibility not to cause transboundary environmental damage”; “principle of preventive action”; “precautionary principle”; “polluter pays principle”; “principle of common but differentiated responsibility” зэрэг зарчмыг үндэсний эрх зүйн хэм хэмжээнд хэрэглэхэд үүсэж болох нэр томьёо болон эдгээр зарчмын агуулгын талаар авч үзлээ. Монгол Улсын үндэсний эрх зүйн хэм хэмжээнд “polluter pays principle” зарчмыг “Бохирдуулагч нь төлөх зарчим” гэсэн нэр томьёог хэрэглэж иржээ.

Харин бусад зарчмын хувьд үндэсний эрх зүйн хэм хэмжээнд тогтсон нэр томьёо хэрэглэгдэж эхлээгүй боловч холбогдох судалгааны бүтээлд монгол хэл дээрх тус тусын нэр томьёоны орчуулга хэрэглэгдэж байна. Гэвч, олон улсын хүрээлэн буй орчны эрх зүйд хэрэглэгдэж буй “principle of preventive action” болон “precautionary principle” зарчмыг “Болгоомжлох арга хэмжээ авах зарчим” болон “Урьдчилан сэргийлэх зарчим” гэж орчуулах нь эдгээр зарчмын хоорондын ялгааг бүрэн илэрхийлж чадахгүй юм. Цаашид, “Principle of preventive action” зарчмыг “Хүрээлэн буй орчинд үзүүлэх шалтгаан нөхцөл болон үүсэх эрсдэл бүхий хохирол хоорондын шалтгаант холбоог тогтооход шинжлэх ухааны бүрэн үндэслэл нотолгоог шаардах зарчим”, “Precautionary principle” зарчмыг “Хүрээлэн буй орчинд үзүүлэх шалтгаан нөхцөл болон үүсэх эрсдэл бүхий хохирол хоорондын шалтгаант холбоог тогтооход шинжлэх ухааны бүрэн үндэслэл нотолгоог шаардахгүй байх зарчим” гэх зэргээр зарчим тус бүрийн агуулгыг илэрхийлэх хэлбэрээр нэр томьёог ашиглах нь оновчтой гэсэн дүгнэлтэд хүрлээ.

²¹ 西井正弘「国際環境法の形成と展開」西井正弘・鶴田順編『国際環境法講義』(有信堂、2021年)11頁。

[Ном зүй]

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 82 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Агаарыг хамгаалах хөтөлбөр” Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=201639> Сүүлд хандсан, 2025.03.12.

Монгол улсын Засгийн газрын 2018.06.20-ны өдрийн “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” дугаар 189 тогтоол, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13515> Сүүлд хандсан, 2025.03.12.

Монгол Улсын Их Хурлын тогтоол, “НҮБ-ын Бага хурлаас дэвшүүлсэн зорилтыг дэмжих тухай” 1993.06.15-ны өдрийн дугаар 43 тогтоол “Хүрээлэн буй орчин ба хөгжлийн тухай Рио-де-Жанейрогийн тунхаглал” Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6367> Сүүлд хандсан, 2025.03.12.

Н.Баярмаа, “Байгалийн баялаг дахь эзэн орны байнгын бүрэн эрхийн зарчим болон уул уурхайн салбарын техник эдийн засгийн үндэслэлийн хууль зүйн үр дагавар”, Хууль зүйн судалгаа бүтээлийн цахим сан, <https://legalddata.mn/buteel/pdf?id=315> Сүүлд хандсан, 2025.03.12.

Т.Сэнгэдорж, С.Энхмэнд, С.Энхсаруул, Олон улсын экологийн эрх зүй, УБ.,2015.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын суурь конвенц, монгол хэл дээрх орчуулга, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail/10695> Сүүлд хандсан, 2025.04.14.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль, Худалдааны бодлогын нэр томъёоны тайлбар толь бичиг, УБ.,2020.

Хууль зүй, дотоод хэргийн яам, “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл, Олон улсын нийтийн эрх зүй, гарын авлага, УБ.,2007

Sands, Philippe. *Principles of International Environmental Law*. Second edition. Cambridge: Cambridge University Press, 2003

北村善宣『環境法、第5版』(有斐閣、2020年)。

大塚直『環境法、第4版』(有斐閣、2020年)。

西井正弘「国際環境法の形成と展開」西井正弘・鶴田順編『国際環境法講義』(有信堂、2021年)。

高村ゆかり「予防原則・予防的アプローチ」西井正弘・鶴田順編『国際環境法講義』(有信堂、2021年)。

[Abstract]

**Basic Principles of International Environmental Law
and Legal Terminology Issues in Mongolian Law**

Sukhbaatar Sukhchuluun

Doctor of Laws (LL.D.)

*Senior Lecturer at the Department of Public Law,
School of Law, National University of Mongolia
Ulaanbaatar, Mongolia*

Although there is no clear definition of the basic principles of international environmental law, the principle of states' sovereignty over their natural resources and the responsibility not to cause transboundary environmental damage; the principle of preventive action; the principle of cooperation; the principle of sustainable development; the precautionary principle; the polluter pays principle; and the principle of common but differentiated responsibility have been identified.

This paper examines the legal terminology issues that may arise when reflecting the basic principles of international environmental law in Mongolian legal norms. For example, this article proposes a method for defining the difference between the 'Principle of Preventive Action' and the 'Precautionary Principle,' as well as suggests terms that could be used in the translation of these principles into future national legal norms.

[Keywords]

Principle of state have sovereignty over their natural resources and the responsibility not to cause transboundary environmental damage; principle of preventive action; precautionary principle; polluter pays principle; principle of common but differentiated responsibility.